


Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2022 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн 01/1720,
дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



ТАНИЛЦУУЛГА

2022 оны 3 дугаар улиралд Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагад хандаж гаргасан иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хүрээнд тус яам болон түүний харьяа, салбар байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, дүн мэдээг танилцуулж байна.

2022 оны 3 дугаар улиралд Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагад нийт 28'841 өргөдөл, гомдол иргэдээс ирсэн байна. Үүнээс 28'787 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд 99.8 хувийн үзүүлэлттэй байна. Одоогийн байдлаар хугацаа болоогүй буюу хуулийн хугацаанд судлагдаж байгаа 37 өргөдөл, гомдол байна.


Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 13 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 11 нь “Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-с ирүүлсэн станцын гэмтэлтэй холбоотой шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд багтсан бөгөөд удирдлагаас өгсөн цаг хугацаанд шийдвэрлээгүй шалтгаанаар хугацаа хоцорсон төлөвтэй байна.

Мөн “Монгол шуудан” ХК нь улс хоорондын шуудан, тээвэрлэлттэй холбоотой иргэдийн гомдолд тухайн илгээмжийг илгээсэн улс руу лавлагаа авах хүсэлтийг илгээж асуудлыг тодруулан шийдвэрлэдэг тул хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын төлөвтэйгээр бүртгэгдсэн байна.

Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 832 бичгээр, 69 цахим хэлбэрээр, 27'803 утсаар, 38 иргэн биечлэн ирж санал, хүсэлтээ илэрхийлсэн байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон түүний харьяа, салбар байгууллагууд нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн хугацааг баримтлан иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулж байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 01/1720
дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт



2022 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс гаргасан
өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал
(Тоон мэдээ)

Хүснэгт №1

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувиар
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	43	40	-	-	3	93%
2	Харьяа байгууллагууд	28798	28747	4	13	34	99.8%
ДҮН		28841	28787	4	13	37	99.8%

2022 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс гаргасан
өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал
(Өргөдөл, гомдлын хэлбэрээр)

Хүснэгт №2

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Бусад				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	43	38	-	5	1	-
2	Харьяа байгууллагууд	28798	794	69	27803	38	93
ДҮН		28841	832	69	27808	39	93

2022 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс гаргасан
 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал
 (Өргөдөл, гомдлын төрөл, агуулгаар)

Хүснэгт №3

Д/д	Төрөл	Тоо	Эзлэх хувь
1	Санал	5827	20,2%
2	Гомдол	755	2.6%
3	Хүсэлт	388	1.3%
4	Мэдээлэл, лавлагаа	21688	75.1%
5	Өргөдөл	81	0.28%
6	Талархал	2	0.006%
7	Бусад	100	0,3%
Нийт:			100%

Д/д	Байгууллага	Зонхилж байгаа асуудал / тоо, эзлэх хувь/
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Нийт 43 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэнээс: - Байгууллагын хүний нөөцтэй холбоотой асуудлаар 23 /53.4%/ - Харьяа, салбар байгууллагын үйлчилгээтэй холбоотой асуудлаар 6 /13.9%/ - Бусад асуудлаар 14 /32.5%/
2	Харьяа байгууллагууд	Нийт 28'798 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэнээс: - Байгууллагын хүний нөөцтэй холбоотой асуудлаар 469 /1.6%/ - Цахим орчинтой холбоотой асуудлаар 198 /0.6%/ - Гэмтэл сааталтай холбоотой асуудлаар 21986 /76%/ - Төлбөр тооцоотой холбоотой асуудлаар 310 /1.0%/ - Улс хоорондын шуудангийн сааталтай холбоотой асуудлаар 61 /0.21%/ - Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлаар 78 /0.27%/ - Бусад 5696 /19.7%/